



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

Засгийн газрын XIII байр, Чингисийн өргөн чөлөө 11,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14251
Утас: (976-51) 26 31 79, Факс: (976-11) 31 23 15,
Цахим шуудан: info@mrtд.gov.mn,
Цахим хуудас: www.mrtд.gov.mn

2024.01.18 № 05а/264
танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих XV.1.1.63 дугаартай “Сумын төвийн хатуу хучилттай авто зам (Ховд, Дөргөн сум)”-ын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилгыг 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Өнөөдөр сонин болон tender.gov.mn сайтад нийтэлсэн.

Тус авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцох хүсэлтэй байгууллагаас “ТШЗ-ны 19.1-д Гэрээг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтад хатуу хучилттай авто замын ажил гүйцэтгэх машин механизм тусгагдсан байгаа” талаар тодруулга ирүүлсэн.

ЗТХЯ/202412080 дугаартай “Сумын төвийн хатуу хучилттай авто зам (Ховд, Дөргөн сум)”-ын барилгын ажлыг гүйцэтгэх тендерийн баримт бичгийн ТШЗ-ны 19.1-д заасан үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалтад тусгагдсан асфальтбетон завод, асфальт дэвсгэгч, автогудорнатор, хийн дугуйт индүү, чулуу бутлуур гэснийг доргиурт хосолмол булт индүү 10-12тн 1ш, бетон дэвсгэгч 3.5м 1ш, суурин бетон зуурагч 0.5м³ 1ш, гар нягтруулагч 120кг 1ш, кран 10тн 1ш нийт 5 машин механизмуудаар сольж, тендерийн материалдаа тусган ирүүлнэ үү.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА
БӨГӨӨД ХУУЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА С.МЯНДАСМАА

